



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 284

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.4.3, 6.4.4, 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Үндэсний аврах бригадын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй нь Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2015 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 02-07-90/721 дүгнэлтээр тогтоогдсон, нийт 102,894,270.00 (нэг зуун хоёр сая найман зуун ерэн дөрвөн мянга хоёр зуун дал) төгрөгийн балансын үнэ, 42,872,612.40 (дөчин хоёр сая найман зуун далан хоёр мянга зургаан зуун арван хоёр төгрөг дөчин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан барилгыг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Үндэсний аврах бригадын дарга захирагч хурандаа Б.Мандахгэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Акталсан барилгын доорх Үндэсний аврах бригадын Сонгинохайрхан дүүрэгт байрлах газарт төрийн өмчийн Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн барилга барих, нөхөн сэргээх, зориулалтаар нь ашиглах, газар эзэмших эрхийг төрийн байгууллагын мэдэлд хэвээр үлдэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001439

15-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 05 дугаар сарын 30 өдрийн
084 дугаар тогтоолын хавсралт



ҮНДЭСНИЙ АВРАХ БРИГАДЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ БАРИЛГА

Д/д	Хөрөнгийн нэр, байршил	Ашиглалтад орсон он	Тоо ширхэг	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Хичээлийн байр (14 айл) Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хороо	1981	1	102,894,270.00	42,872,612.40	60,021,657.60
Чийт дүн				102,894,270.00	42,872,612.40	60,021,657.60
				(нэг зуун хоёр сая найман зуун ерэн дөрвөн мянга хоёр зуун далан)	(дөчин хоёр сая найман зуун далан хоёр мянга зургаан зуун арван хоёр төгрөг дөчин мөнгө)	(жаран сая хорин нэгэн мянга зургаан зуун тавин долоон төгрөг жаран мөнгө)